

## ТАНИЛЦУУЛГА

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг  
зарцуулах, түүнд хяналт тавих  
журмын талаар

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2.4</sup>-т “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.” гэж заасан.

Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын төслийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсрууллаа.

Журмын төсөлд сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, мөнгөн бус хандивын хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулах, сангаас санхүүжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэн, сонгон шалгаруулж шийдвэрлэх, чиг үүрэг бүхий Удирдах хороотой ажиллахаар зохицуулж, хорооны болон ажлын албаны хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тусгасан болно.

Түүнчлэн Удирдах хороо нь сангийн хөрөнгөөс тухайн жилд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт болон шагнал урамшуулал, дэмжлэгт зарцуулах хөрөнгийн хувь хэмжээ, санхүүжилтийн дэмжлэг авах бүтээн байгуулалтыг сонгон шалгаруулж, шийдвэрийг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд танилцуулах, Сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлан мэдээллийг хэлэлцэн дүгнэлт гаргадаг байхаар зохицууллаа.

Сангийн эх үүсвэрийг төвлөрүүлэхэд олон улсын байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг сангийн дансанд бэлэн бус хэлбэрээр, мөнгөн бусаар ирүүлсэн хандив, тусламжийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаалж, санд бэлэн бус хэлбэрээр төвлөрүүлэх, олон нийтэд нээлттэй мэдээлж байх заалтыг тусгалаа. Ингэснээр сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих нөхцөл боломж бүрдэнэ гэж үзсэн.

Сангийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2.3</sup>-д заасан хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих; олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах; олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх; үйл ажиллагааг санхүүжүүлэхэд тавигдах болзол шалгуур, бүрдүүлэх баримт бичгийг, шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан. Ингэхдээ сангаас хөрөнгө оруулалт, дэмжлэг урамшуулал хүссэн этгээдэд ил тод, хүндрэлгүй, ойлгомжтой байдлаар зохицуулалтыг тусгахад чиглэгдсэн болно.

Журмын хасвралтаар баталсан соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, олимпиадын жагсаалт нь Засгийн газраас баталсан Олон улсын олимпийн хорооны ивээл доор зохион байгуулагддаг спортын тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, олон улсын хэмжээнд зохиогддог өсвөрийн уран бүтээлчдийн их наадам зэрэг уралдаан тэмцээн наадмын жагсаалттай давхцаагүй байхаар

зохицуулсан. Энэ нь Засгийн газраас олгож буй шагнал урамшуулалтай сангаас давхцуулан олгохгүй байх нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн сангийн хөрөнгөнд олон нийтийн хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, албан ёсны цахим хуудсаар дамжуулж, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, сангаас урамшуулал, дэмжлэг авсан хүүхэд, олгосон хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг тусгав.

---oOo---